

БОРЖИГИН СЭЦЭН ВАНГИЙН ХОШУУНЫ ГАЗАР НУТАГ

Үндэсний номын сангийн Монгол номын фондод хадгалагдаж байгаа эхээс буулгав

Боржигин Тавнангууд Ш.Сонинбаяр

Тост Боржигины тал нутаг

Богд Чингис хаанаас алтан ургийн үет тасралтгүй дараалан залгасан 27-р үе Батмөнх Даян хааны арван нэгэн хөвгүүний 10-р Гэрсэнз Залайр хунтайжийн 6-р хөвгүүн Амин дурал түүний хүү Мөр Буймэн, Мөр Буймэнгийн хүү Маха Самади Гэгээн Сэцэн хан Шолойн арван нэгэн хөвгүүдээс Сэцэн хан аймгийн 23 засаг хошууны ноёдын угсаа салбарлан гарсан байдаг. Шолой Сэцэн ханы 8-р хүү Бадамдаш далай хунтайжийн хүү Дамбадаш хун тайжийн ахмад хүү Цэвдэн бэйл цол нь эрх тайж хэмээмэй. Манж Чин улсын Энх-Амгалангийн 30-р онд \1691\ Засаг төрийн бэйл өргөмжлөгдөж хошуу захирах болсон үеэс эхлэн дараалан арван ноёны нүүр үзэж сүүлчийн ноён хошой чин ван Гомбосүрэнгийн үеийг хүртэл гурван зуу гаруй жилийн турш явж ирсэн түүхтэй. Манж Чин улсын үед Халхын Дорно замын Баруун гарын дунд засаг төрийн бэйлийн хошуу гэж байх үеэс суурьшжээ. Мөн Халхын олон хошуудын газар нутгийн “Ойллого” бичиг хэмээхэд бэйл Цэвдэн Хэрлэн голд нутаглахын зэрэгцээ зүүн тийш Эрхийн Яр хад, баруун тийш Бичигт хар хад, өмнүүр Хөх дэрс, хойд тал нь Сансар, Зараа хүрнэ хэмээжээ. Мөн зүүн тийш Өлгий хүрч Баруун гарын дундад баруун этгээдийн хошуу лугаа зах нийлнэ. Өмнүүр улаан толгой хүрнэ. Түшээт хан аймгийн Зүүн гарын дундад хошуу лугаа зах нийлмэй. Баруун тийш Их газрын чулууны Ачит улаан хүрч Түшээт хан аймгийн Зүүн гарын баруун этгээдийн адгийн хошуу лугаа зах нийлмэй. Хойгуураа баян хар хүрнэ. Түшээт хан аймгийн дундад хошуу лугаа зах нийлмэй. Зүүн хойш Бөгтөр хар ус хүрнэ. Баруун гарын Дундад өмнөд хошуу Жич: Түшээт хан аймгийн зүүн гарын Дундад хошуу лугаа зах нийлнэ. Баруун өмнө тийш Улаан хөөврийн ус хүрнэ. Түшээт хан аймгийн Зүүн гарын Дундад хошуу лугаа зах нийлнэ хэмээн тэмдэглэжээ.

Боржигин сэцэн вангийн хошууны газрын зургууд Үндэсний төв архив, Улсын төв номын сан, Дундговь аймгийн орон нутгийн судлах музей зэрэг газарт хадгалагдан үлдсэн байна. Эдгээр нь хоорондоо ерөнхийдөө адилагтар боловч нэлээд зөрөөтэй байгаагийн дотроос Улсын төв номын санд хадгалагдаж байгаа нэг зургийг сонгон авч үндсэн чиг баримжаа болгосон юм. Энэ зургийг Олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны зуны дунд сарын арванд үйлдэж Дотоод яамнаа өргөхдөө газрын зургаас гадна хошуу нутгийн хилийн овоодын нэрийг заан бичсэн Цэс үйлдэж хавсарган өргөсөн байна. Бид хошуу Ганжуур эргэхдээ энэ хоёр чухал бичиг баримтуудыг үндэслэн замд гарсан юм.

Ш.Сонинбаяр

Шашины Дээд Сургууль

Фүтаки Хироши, Камимүра Акира, Э.Равдан, Л.Чулуунбаатар

Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд
МУИС пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012, ISBN 978-99962-72-59-2

Тус хошууны нутаг өргөн уудам бөгөөд Түшээт хан аймгийн Дархан Чин вангийн хошуу, мөн аймгийн Ахай гүний хошуу, мөн аймгийн Хардэл жанжин бэйсийн хошууны нутагтай хил залгаж байжээ. Энэ нь одоогийн Төв аймгийн Баянцагаан, Баян, Баянжаргал сумдаас гадна Хэнтий аймгийн Дархан, Буянт сум, Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сум, Дорноговь аймгийн Их хэт, Дэлгэрэх, Алтанширээ, Айраг, Сайхандулаан, Даланжаргал сумдаас гадна Дундговь аймгийн Өндөршил, Баянжаргал, Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Цагаандэлгэр сумдын нутгаар савлаж байна. Боржигжин сэцэн вангийн хошууны нутгийн хэлбэрийг хонины ходоод, гүзээтэй тос хэлбэртэй гэж эртнээс ярьж ирсэн уламжлалтай. Хошууны зүүн хойд хилийн орчим оршдог Баян-Эрхтий уулыг хонины ходоодны ам гэдэг. Тус хошууны нутагт Их газрын чулуу, Бичигтийн чулуу, Аргийн чулуу, Нардын чулуу, Бүсийн чулуу, Бударын чулуу, Ширийн чулуу зэрэг байгалийн хосгүй сайхан үзэсгэлэнтэй уул хадаас гадна нутгийн дөрвөн Баян гэж алдаршсан Баян-Эрхтий, Баян уул, Их Баян, Баян улаан зэрэг хээр талын чимэг болон сүндэрлэсэн уулнууд байхын зэрэгцээ Өмэгэй Сэцэн ханы үеэс сүлд тахилгатай болж удаа дараагийн хошуу ноёдын шарил залж байсан Их хонгор уулыг хошууны гол овоо хэмээн сүслэн биширч ирсэн уламжлалтай. Боржигин Сэцэн вангийн хошуу ноёдын тахиж ирсэн Зүүн Чойрын Богд уул, Сансар, Баруун Чойр хийдийн лам нар тайж тахидаг байсан Их Залаагаас гадна тус хошууны 44 отог тус тусдаа өөр өөрийн тахьдаг уул овоотой байсан байна. Хээр талын өргөн уудам нутгийг хамарсан энэ жонш гялтганын гол орд болох Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр, Айраг, Цагаандэл, Зүлэгт, Хажуу улаан зэргийг нэрлэж болно. Хөх Монгол улсын Богд Чингис хааны амьдрал түүхтэй холбоотой Их газрын чулуу, зүүн баруун Цавчир, Чингис хааны адууны нутаг гэж алдаршсан Малахын тал, Яргай, Цайдмыг дурьдууштай юм. Боржигин Сэцэн вангийн хошууны нутагт мянга гаруй шавьтай гүн ухаан, одон зурхай, анагаах ухаан зэрэг сургалтын төрөл бүрийн дацангууд бүхий Зүүн Чойр, Баруун Чойр хийдээс гадна үргэлжийн хуралтай Алтадын жас, Цагаан дэлийн хийд, Цоорын хийд, Уулын мамба, Бага нардын Ламрим хийдээс гадна гуч гаруй бага жасууд хурал номын үйл ажиллагаа явуулж ирсэн байна. Сэцэн хан аймгийн 23 засаг хошуудын дотроос газар нутгийнхаа хэмжээгээр томоохонд орж байсан Боржигин Сэцэн вангийн хошуун Ганжуур эргэдэг хошууны голлох хийд Зүүн Чойр хийдээс Цогчин гэсгүй, Ганжуурын даамал нараас өргөө тамгын газар түшмэдүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр жилд нэг удаа зохион явуулж ирсэн байна. Зүүн Чойр хийдийн Ганжуур жас Бурхан багшийн айлдсан 108 боть Ганжуураа залж, арван зургаагаас доошгүй лам нарыг татан ирүүлж ноёны өргөө, тамгын газраас томилогдсон түшмэдийн хамтаар явахдаа тэмээнд Ганжуураа ачаад Хэрлэнгийн Зараа булангаас эхлэн нутгийн сав дээс газруудаар явж хошуу нутгийн дөрвөн зүг найман зовхист үдэж, Ганжуур хурж явдаг байсан юм. Ингэж явахдаа нийтдээ сар гаруй хугацаагаар тойрдог байсан уламжлалтай. Хошуу нутгийн хил хязгаарыг сахин хамгаалж байсан овоочингуудад зар өгч хоол хүнс, улааны албыг залгуулахыг тушаан мэдэгдсэний дагуу зохих бэлтгэлийг хангасан байдаг байжээ. Ер нь Монголын олон хошуу нутагт хошуу нутгийнхаа дээс саваар явж, Ганжуур эргэдэг байсан заншил түгээмэл байсан байна. Ингэж Ганжуур эргэснээр Бурхан багшийн айлдвар номлолын охь шим болсон хөлгөн судруудаар нутаг орон хүн ардаа адислаж тэр жилийнхээ зун нь ган гачиггүй, өвөл нь зуд турхангүй өнгөтэй орохоос гадна элдвийн өвчин тахал гай барчид, самуун тэмцэл үл гарахын гүн билэгдлийг оршоож байхын агуулгыг хадгалсан ач холбогдолтой юм. Сүүлийн үед аймаг сумдын хил хязгаарыг буруу тогтоосноос болж газар нутгаа булаацалдах, хэл ам, хэрүүл тэмцэл гарсан дуулддаг. Иймд тодорхой баримттай тэмдэглэл, дансны дагуу Ганжуур эргэж байгаа нь сумдын газар нутгийн хилийг зөвөөр тогтооход өчүүхэн ч атугай ач холбогдлыг өгнэ гэдэгт найдна. Эх орон газар нутагтаа хайргүй хүн гэдэг байж болшгүй учраас ирээдүй болсон хойч үеийнхэнд уламжлалт ёс заншилаа сэргээхэд бидний энэ зорьсон хэрэг нэмэр болох нь дамжиггүй. Бурхан багшийн айлдсан Ганжуур номын цаглашгүй их ач тусыг өгүүлж баршгүй. Ийм учраас сүсэгтэн олон нийтээр бие хэл сэтгэл гурвын үүднээс оролцож байвал их буян хураахын дээр нүгэл хилэнц нимгэрнэ гэдэгт итгэж байна.

Сэцэн хан аймгийн сэцэн ван Гомбосүрэнгийн хошуу нутгийн цэс

Сэцэн хан аймгийн арван зэрэг нэмсэн долоон зэрэг тэмдэглэсэн сэцэн засаг хошой чин ван Гомбосүрэнгийн хошууны нутаг лугаа зах нийлэх ба хязгаар уулзах засаг хошууд овооны нэр тоо хоорондох газар мөн эргэн тойрны хэмжээ зэргийг тус тус тодорхойлон цэс үйлдэж өргөх нь:

Харьяат нутгийн зүүн өмнийн

1-р Баянтээгийн өмнө үзүүр дээрх овооноос

2-р Гуа дэнжийн овоо хүртэл хөхөөс цагааны зүг арван дөрвөн газар, нэг хувь, хорин есөн алд энэ овооноос

3-р Улаан толгойн хойд дахь усны овоо хүртэл туулайнаас тахианы зүг зургаан газар, дөрвөн хувь, энэ овооноос

4-р Улаан толгойн баруун хойд дэнжийн овоо хүртэл үхрээс хонины зүг, таван газар, дөрвөн хувь гучин таван алд энэ овооноос

5-р Цагаан гуагийн овоо хүртэл зогсолтоос эсвэргүү хүртэл арван хоёр газар, 6 хувь, 25 ард энэ овооноос

6-р Бор хошууны өмнөх цагаан гуа дээрх овоо хүртэл хөхөөс цагаан зүг 9 газар, 6 хувь, 25 алд энэ овооноос

7-р Олох овооны тус өмнөх гуа овог дээрх овоо хүртэл барсаас бичний зүг 9 газар, 6 хувь, 25 алд энэ овооноос

8-р Улаан гуа дээрх овоо хүртэл хөхөөс цагааны зүг 20 газар, 3 хувь, 34 алд энэ овооноос

9-р Улаан толгой дээрх овоо хүртэл туулайнаас тахианы зүг 9 газар 4 хувь, 21 алд энэ овооноос

10-р Гуа толгой дээрх овоо хүртэл хөхөөс цагааны зүг 8 газар, 8 хувь, энэ овооноос

11-р Цагаан толгой дээрх овоо хүртэл зогсолт, үхрийн завсраас хонь ээвэргүүн завсрын зүг 6 газар, энэ овооноос

12-р Хамаг усны зүүн өмнөх хар овоон дээрх овоо хүртэл барсаас бичний зүг 13 газар, 15 алд энэ овооноос

13-р Хамаг усны өмнөх хар тал дээрх овоо хүртэл зогсолтоос ээвэргүүн зүг 2 газар, 4 хувь, 28 алд энэ овооноос

14-р Хар толгой дээрх овоо хүртэл туулайнаас тахианы зүг 7 газар, 3 хувь, 6 алд энэ овооноос

15-р Тал дээрх овоо хүртэл хөхөөс цагааны зүг 8 газар, 7 хувь, 18 алд энэ овооноос

16-р Цагаан дэнж дээрх овоо хүртэл барсаас бичний зүг 9 газар, 2 хувь, 19 алд энэ овооноос

17-р Цагаан гуагийн товог хүртэл зогсолтоос эсвэрхүүн зүг 7 газар, 2 хувь, 26 онд энэ овооноос

18-р Хөөврийн зүүн этгээд дэх овоо хүртэл барс зогсолтын завсраас ээвэргүүн бичний завсрын зүг 22 газар энэ овооноос

19-р Хөөврийн усны баруун дэргэдэх овоо хүртэл хөхөөс цагааны зүг 2 газар, 9 хувь, 6 алд энэ овооноос

20-р Цагаан гуа дээрх овоо хүртэл оролго луугийн завсраас нохой мөнхийн завсрын зүг 9 газар, 2 хувь энэ овооноос

21-р Мөн цагаан гуа дээрх овоо хүртэл оролго луугийн завсраас нохой мөнхийн завсрын зүг 10 газар, 9 хувь, 13 алд энэ овооноос

22-р Улаан зээгийн баруун үзүүр дээрх овоо хүртэл луугаас нохойн зүг 11 газар, 3 хувь, 1 алд энэ овооноос

23-р Сайн усны баруунтаа цагаан гуа дээрх овоо хүртэл оролго луугийн завсраас нохой мөнхийн завсрын зүг 22 газар, 7 хувь, 32 алд энэ овооноос

24-р Гүн усны баруун өмнөд гуа товог дээрх овоо хүртэл орлого луугийн завсраас нохойн

- мөнхийн завсрын зүг 14 газар, 6 хувь, 27 алд энэ овооноос
- 25-р Бага хадны дунд нуруу дээрх овоо хүртэл луугаас нохойн зүг 9 газар, 5 хувь, 4 алд энэ овооноос
- 26-р Мөн бага хадны дунд нуруу дээрх овоо хүртэл харагчингаас улаагчин зүг 2 газар, 7 хувь, 14 алд энэ овооноос
- 27-р Дэрсны усны өмнө овоон дээрх овоо
- 28-р Дэрсний усны баруун хар овоон дээрх овоо
- 29-р Үүд усны өмнө дэргэд Гуа толгой дээрх овоо
- 30-р Нарийн харын зүүн дэнж дээрх овоо
- 31-р Сэрвэнгийн зүүн дэнж дээрх овоо
- 32-р Их хадны өвөр гашуун усан дээрх овоо хүртэл туулайнаас тахианы зүг 8 газар, 8 хувь, 22 алд энэ овооноос
- 33-р Их хадны орой дээрх овоо хүртэл луугаас нохойн зүг 10 газар, 5 хувь энэ овооноос
- 34-р Мөн хадны хойд ар дээрх овоо хүртэл оролгоос мөнхийн зүг 3 газар, 6 хувь, 10 алд энэ овооноос
- 35-р Мөн хадны хойд этгээд ар сүүл хэмээх овоо хүртэл луугаас оролгын завсраас нохой мөнхийн завсрын зүг 6 газар, 4 хувь, 32 алд энэ овооноос
- 36-р Талын дэнж дээрх овоо хүртэл оролго могойн завсраас мөнх гахайн завсрын зүг 23 газар, 4 хувь, 6 алд энэ овооноос
- 37-р Мөн тал дээрх овоо хүртэл оролгоос мөнхийн зүг 4 газар, 9 хувь, 26 алд энэ овооноос
- 38-р Хар зээгийн баруун үзүүр дундах овоо хүртэл оролгоос мөнхийн зүг 17 газар, 9 хувь, 1 алд энэ овооноос
- 39-р Ар хар зээгийн зүүн өмнө үзүүр дээрх овоо хүртэл оролгоос мөнхийн зүг 5 газар, 2 хувь, 21 алд энэ овооноос
- 40-р Ар хар зээгийн зүүн хойд захын овоо хүртэл оролгоос мөнхийн зүг 2 газар, 6 хувь, 14 алд энэ овооноос
- 41-р Элэгний усны баруунаа цахиурт овоон дээрх овоо хүртэл оролгоос мөнхийн зүг 15 газар, 5 хувь, 15 алд энэ овооноос
- 42-р Хөөтийн баруун тал дээрх овоо хүртэл оролго могойн завсраас мөнх гахайн завсрын зүг найман газар энэ овооноос
- 43-р Цагаан усны баруунтаа нэг овооны дээрх овоо хүртэл оролгоос могойн завсар мөнх гахайн завсрын зүг 10 газар, 2 хувь, 4 алд энэ овооноос
- 44-р Улаан овоон дээрх овоо хүртэл оролгоос мөнхийн зүг 5 газар, 8 хувь, 31 алд энэ овооноос
- 45-р Зүүн бөөрийн өмнө шинэ усны хойд овоон дээрх овоо хүртэл оролгоос мөнхийн зүг 13 газар, 9 хувь, 29 алд энэ овооноос
- 46-р Гүн усны баруунтаа өндөр хар овоон дээрх овоо хүртэл оролгоос мөнхийн зүг 9 газар, 18 алд энэ овооноос
- 47-р Ачит улааны өмнө дэргэд нэгэн орой дээрх овоо хүртэл луу оролгын завсраас нохой мөнхийн завсрын зүг 12 газар, 1 хувь, 23 алд энэ овооноос
- 48-р Ачит улааны нэгэн ар дээрх овоо хүртэл улаан морины завсраас хар хулганы завсрын зүг хоёр газар, таван хувь, хорин долоон алд энэ овооноос
- 49-р Баян улааны баруун өмнө Балингийн суварга хэмээх өндөр улаан хадны зүүн өмнө өндөр улаан хадны дундах овоо хүртэл морины завсраас хар хулганын завсрын зүг хоёр газар, таван хувь, долоон алд энэ овооноос
- 50-р Баян улааны баруун хойд Сэнжитийн усан дээрх овоо хүртэл улаанаас харын зүг 10 газар, 8 хувь, 31 алд энэ овооноос
- 51-р Хөтөл усны баруунтаа ман хөтөлийн амны усан дээрх овоо хүртэл улаан морины завсрын хар хулганы завсрын зүг 4 газар, 5 хувь, 22 алд энэ овооноос
- 52-р Ар булгын усан дээрх овоо хүртэл улаан морины завсраас хар хулганы завсрын зүг 6 газар, 7 хувь, 17 алд энэ овооноос

- 53-р Ерлөгийн гол 2 өндрийн хоорон дахь тахилгын өлт хөтөлийн дундахь зүүн улаан толгой дээрх овоо хүртэл улаан морины завсраас хар хулганы завсрын зүг 7 газар энэ овооноос
- 54-р Баруун дулааны баруун хойд улаан толгой дээрх овоо хүртэл улаан морины завсраас хар хулганы завсрын зүг 11 газар, 6 хувь, 12 алд энэ овооноос
- 55-р Зүүн цавчирын усан дээрх овоо хүртэл улаанаас харын зүг 3 газар, 1 хувь, 24 алд энэ овооноос
- 56-р Улаан товог дээрх овоо хүртэл могойноос гахайн зүг 9 газар, 2 хувь, 30 алд энэ овооноос
- 57-р Тавдай худгийн тал булгын нэгэн залгаа усан дээрх овоо хүртэл могойноос гахайн зүг 8 газар, 8 хувь, 28 алд энэ овооноос
- 58-р Гашууны усны баруунтаа бууцат хар толгойн хойд дэргэд бяцхан хар толгой дээрх овоо хүртэл могой улааны завсраас гахай харын завсрын зүг 10 газар, 7 хувь, 6 алд энэ овооноос
- 59-р Гурван түрүү усны баруунтаа бяцхан бор хошуу дээрх овоо хүртэл улаан морины завсраас хар хулганы завсрын зүг 6 газар, 6 хувь, 4 алд энэ овооноос
- 60-р Гол овоот хэмээх нэгэн хүрэн өндөрийн зүүн хойд бяцхан хар тал дээрх овоо хүртэл улаан морины завсраас хар хулганы завсрын зүг 8 газар, 2 хувь, 20 алд энэ овооноос
- 61-р Сүүж усан дээрх овоо хүртэл улаан морины завсраас хар хулганы завсрын зүг 10 газар, 6 хувь, 24 алд энэ овооноос
- 62-р Гучин хэмээх усан дээрх овоо хүртэл улаан морины завсраас хар хулганы завсар зүг 11 газар, 5 хувь 10 алд энэ овооноос
- 63-р Дэлгэр далайн усны баруунтаа бяцхан улаан толгой дээрх овоо хүртэл мориноос хулганы зүг 7 газар, 5 хувь, энэ овооноос
- 64-р Буурцат улаан толгой дээрх овоо хүртэл улаагчин морины завсраас хулгана харагчны завсрын зүг 13 газар, 7 хувь, 10 алд энэ овооноос
- 65-р Сангийн далайн худгийн усан дээрх овоо хүртэл улаагчнаас харагчины зүг 12 газар энэ овооноос
- 66-р Хонхор усан дээрх овоо хүртэл тахианаас туулайн зүг 17 газар, 2 хувь энэ овооноос
- 67-р Хэрээ шандны усны дээрх овоо хүртэл тахианаас туулайн зүг 15 газар энэ овооноос
- 68-р Улаан худгийн усны дээрх овоо хүртэл тахианаас туулайн зүг 6 газар энэ овооноос
- 69-р Балтастай усан дээрх овоо хүртэл тахианаас туулайн зүг 22 газар энэ овооноос
- 70-р Замын хөтлүүд дээрх овоо хүртэл тахианаас туулайн зүг 10 газар энэ овооноос
- 71-р Баян харын зүүн хойд этгээд цагаан чулуутын баруун өмнө таван худаг усны хойд нэгэн өндөр дээрх овоо хүртэл ээвэргээс зогсолтын зүг 13 газар энэ овооноос
- 72-р Хулгар худгийн усан дээрх овоо хүртэл хониноос үхрийн зүг 20 газар энэ овооноос
- 73-р Хөх даамал усан дээрх овоо хүртэл хониноос үхрийн зүг 37 газар энэ овооноос
- 74-р Төгрөгийн усан дээрх овоо хүртэл ээвэргээс зогсолтын зүг 11 газар энэ овооноос
- 75-р Тойром усан дээрх овоо хүртэл цагаанаас хөхийн зүг 16 газар энэ овооноос
- 76-р Модон худгийн усан дээрх овоо хүртэл цагаанаас хөхийн зүг 8 газар энэ овооноос
- 77-х Хөндий талын төв дундахь овоо хүртэл ээвэргээс зогсолтын зүг 19 газар энэ овооноос
- 78-р Гашуун усан дээрх овоо хүртэл цагаанаас хөхийн зүг 15 газар энэ овооноос
- 79-р Өлзийт хошууны гээг зэгст бөгтөр хар хэмээх усны овоо хүртэл бичнээс барсын зүг 16 газар энэ овооноос
- 80-р Өлзийт хошууны зүүн суга дээрх овоо хүртэл гахайнаас могойн зүг 7 газар, 4 хувь энэ овооноос
- 81-р Өчүүхэн хар зээг дээрх овоо хүртэл хараас улааны зүг 13 газар, 7 алд энэ овооноос
- 82-р Баян эрхтий уулын оргил дээгүүр өмнөд олон булаг хэмээх булгуудын зүүн зах дундуур дайруулан өмнөх захын булгийн зүүн этгээд овоонд хүртэл хараас улааны зүг 13 газар, 4 алд энэ овооноос

- 83-р Түнтгэр гуагийн орой овоо хүртэл хараас улааны зүг 13 газар, 1 хувь, 10 алд энэ овооноос
- 84-р Манахын зүүн гашуун хэмээх хоёр усны хоорон дахь овоо хүртэл гахайнаас могойн зүг 24 газар, 20 алд энэ овооноос
- 85-р Бумбат хэмээх хоёр усны баруун өмнөд худаг усны зүүн этгээд дэх овоо хүртэл гахайнаас могойн зүг 22 газар, 16 алд энэ овооноос
- 86-р Яргайн ар сайн шандны баруун этгээд ар шандны зүүн дээгүүр зараа өндөрийн баруун этгээд холбоо өндөрийн зүүн этгээд улаан өндөр дээрх овоо хүртэл гахайнаас могойн зүг 35 газар, 1 хувь, 31 алд энэ овооноос
- 87-р Хөтөлийн баруун худаг усан дээрх овоо хүртэл гахайнаас могойн зүг 18 газар, 24 алд энэ овооноос
- 88-р Цагаан дэлийн баруун мөрөн дээрх дээгүүр Булшт ус улаан дэлийн шанд хоёрын хоорондуур улаан өндөрийн зүүн хажуу дайруулан баруун салхитын зүүн өлт хөтөл дээрх овоо гахай мөнхийн завсар зүг 27 газар, 3 хувь 32 алд энэ овооноос
- 89-р Өлгий уулын тахилгат оргилын зүүн өвөр орой дээрх овоо хүртэл гахайнаас могойн зүг 17 газар, 1 хувь, 15 алд энэ овооноос
- 90-р Шилийн худгийн усан дээрх овоо хүртэл нохойноос луугийн зүг 29 газар, 4 хувь, 21 алд энэ овооноос
- 91-р Холбоо хонхорын хөтөл дээрх овоо хүртэл нохойноос луугийн зүг 21 газар, 3 хувь, 24 алд энэ овооноос
- 92-р Улаан зэргийн дунд хөх өндрийн зүүн хойд нуруу дээрх овоо хүртэл цагаагчнаас хөхөгчний зүг 16 газар, 7 хувь, 23 алд энэ овооноос
- 93-р Хөгцөт хөөврийн хоёр усны өмнөд усан дээрх овоо хүртэл цагаагчнаас хөхөгчний зүг 4 газар энэ овооноос
- 94-р Сайн цагаан хэмээх эхэн цагаан усан дээрх овоо хүртэл хулганаас морины зүг 15 газар, 22 алд энэ овооноос
- 95-р Муу сайн хар толгойн усан дов ус гурван хөөвөр усны хойд этгээдээр хар тойром Шар худаг устын өмнө дэргэдүүр эгц шулуун элст өндөрийн оргил дээгүүр өвөр улаан усны хойд дэргэдэх овоо хүртэл тахиа цагааны завсраас туулай хөхийн завсрын зүг тавин нэгэн газар, 3 хувь, 12 алд энэ овооноос
- 96-р Бага эрээний зүүн оргил орой дээрх овоо хүртэл гахай мөнхийн завсраас оролго могойн завсрын зүг 22 газар, 6 хувь, 4 алд энэ овооноос
- 97-р Тагт хулгар худгийн усан дээрх овоо хүртэл бичнээс барсын зүг 21 газар, 5 хувь, 20 алд энэ овооноос
- 98-р Хар айргийн зүүн этгээд адаг сүүж усан дээрх овоо хүртэл цагаагчнаас хөхөгчний зүг 16 газар, 2 хувь, 32 алд энэ овооноос
- 99-р Хадат улаан толгой дээрх овоо хүртэл цагаагчнаас хөхөгчний зүг 13 газар 11 алд энэ овооноос
- 100-р Өндөр улаан овоон дээрх овоо хүртэл бичнээс барсын зүг 3 газар 13 алд энэ овооноос
- 101-р Өвөр давхар гашуун ус шинэ усны хоорондахь цагаан товгийн зүүн суга дэнж дээрх овоо хүртэл цагаагчнаас хөхөгчний зүг 5 газар, 2 хувь, 26 алд энэ овооноос
- 102-р Гашуун булгийн эхний ус гучны адаг усны хоорондахь хошуу овоо хүртэл нохойноос луугийн зүг 9 газар, 5 хувь, 26 алд энэ овооноос
- 103-р Ар давхар гашуун усдын зүүн хойд бор товог дээрх овоо хүртэл мөнхөөс оролгын зүг 5 давхар, 9 хувь, 14 алд энэ овооноос
- 104-р Баруун баяны зүүн этгээд хар өндөр дээрх овоо хүртэл мөнхөөс оролгын зүг 10 газар, 20 алд энэ овооноос
- 105-р Цагаан өндөр дээрх овоо хүртэл нохойноос луугийн зүг 4 газар энэ овооноос
- 106-р Хар чулуут хэмээх хадатын зүүн хойд үзүүр хар хад дээрх овоо хүртэл мөнхөөс оролгын зүг 11 газар энэ овооноос

- 107-р Цагаан хөтлийн хойд дахь улаан товог дээрх овоо хүртэл хулганаас морины зүг 10 газар, 1 хувь, 3 алд энэ овооноос
- 108-р Дэрсэнэ усны баруун цагаан хөтөл овоо хүртэл мөнхөөс оролгын зүг 1 газар, 4 хувь, 7 алд энэ овооноос
- 109-р Өндөр хар толгой дээрх овоо хүртэл хөхөөс цагааны зүг 7 газар, 2 хувь энэ овооноос
- 110-р Хар энгэрийн сайн усан дээрх овоо хүртэл зогсолтоос эвэргүүн зүг 4 газар, 6 хувь, 16 алд энэ овооноос
- 111-р Цагаан чулуут тал дээрх овоо хүртэл зогсолтоос эвэргүүн зүг 11 газар, 4 хувь, 29 алд энэ овооноос
- 112-р Их цагаан овоо дээрх овоо хүртэл зогсолтын завсраас эвэргүү хонины завсрын зүг 8 газар, 4 хувь, 8 алд энэ овооноос
- 113-р Хулгар усны өмнөх хах толгой дээрх овоо хүртэл зогсолт барсын завсраас эвэрэх бичний завсрын зүг 10 газар, 3 хувь, 13 алд энэ овооноос
- 114-р Хулгарын усны баруун хойд дахь хөх толгой дээрх овоо хүртэл хөхөөс цагааны зүг 4 газар, 8 хувь, 9 алд энэ овооноос
- 115-р Муу хөтөл усны зүүн улаан толгой дээрх овоо хүртэл барсаас бичний зүг 15 газар, 4 хувь, 30 алд энэ овооноос
- 116-р Муу хөтөл усны баруунтаа нэгэн цагаан овоон дээрх овоо хүртэл барсаас бичний зүг 7 газар, 27 алд энэ овооноос
- 117-р Сүүж усны зүүн улаан дэл дээрх овоо хүртэл зогсолтоос эвэрхийн зүг 12 газар, 6 хувь, 33 алд энэ овооноос
- 118-р Сүүж усны баруунтаа нэгэн өчүүхэн хошуу дээрх овоо хүртэл барсаас бичний зүг 8 газар, 4 хувь, 8 алд энэ овооноос
- 119-р Нэгэн цагаан нуруу дээрх овоо хүртэл хөхөөс цагааны зүг 4 газар, 35 алд энэ овооноос
- 120-р Шар хүнхэрийн өмнө нэгэн цагаан нуруу дээрх овоо хүртэл хөхөөс цагааны зүг 12 газар, 4 хувь, 13 алд энэ овооноос 1-р Баянтээгийн өмнө үзүүр дээрх овоо хүртэл хөхөөс цагааны зүг 18 газар эдгээр овоодын доторх 108-р Цагаан хөтлийн овооноос 26-р Бага хадатын овоо хүртэл энэ 39 овоонд цөм Түшээт хан аймгийн мэргэн ван Ринчэнбадамбазарын хошуу лугаа зах нийлмой. Энэ овооноос үүсгэн 30-р нарийн харын овоо хүртэл энэ таван овоонд мөн аймгийн ачит гүн Бадрахын хошуу лугаа зах нийлмой. Энэ овооноос үүсгэн 65-р сангийн далайн худаг усны овоо хүртэл энэ 36 овоонд цөм мөн аймгийн Дайчинбэйл Мөнх-Очирын хошуу лугаа зах нийлмой. Энэ овооноос үүсгэн 79-р Бөтгөр хар усны овоо хүртэл энэ 15 овоонд цөм мөн аймгийн чуулганы дарга дархан чин ван Пунцагцэрэнгийн хошуу лугаа хязгаар заагалцмой. Мөн энэ овооноос үүсгэн 96-р Бага эрээний овоо хүртэл энэ 18 овоонд цөм нэгэн аймгийн ахай гүн Чагдаргочоо агсаны хошуу лугаа зах нийлмой. Энэ овооноос үүсгэн 108-р Цагаан хөтлийн овоо хүртэл энэ 13 овоонд нэгэн аймгийн сайд бишрэлт хошой чин ван Доржцэрэнгийн хошуу лугаа зах нийлмой. Үүнээс дээш харьяат аймгийн нэгэн засаг хошуу лугаа нэгэн овоонд хязгаар уулзаж мөн аймгийн 2 засаг хошуу Түшээт хан аймгийн 4 засаг хошуу лугаа зах нийлсэн тойрон 120 овооны хоорондын хэмжээ бүгд 1399 газар, 7 хувь, 9 алд харьяат хошууны нутгийн өмнө этгээд Цагаан өндөрийн овооноос баруун этгээд улаан хадатын дундах овоонд хүртэл эрслэн 433 газар болохоос гадна нутгийн хойд зах Бөтгөр хар усны нэгэн овоонд нийслэл хүрээний зүүн өмнө зүгийн Бөтгөр хар усны өртөөний нутаг тохиолдмуй.

Олноо өргөгдсөний арван нэгдүгээр он
зуны дунд сарын арван

Хошуу нутгийн цэсд орсон зарим үгийн тайлбар

1. Арван зэрэг нэмсэн, долоон зэрэг тэмдэглэсэн хэмээх нь Манжийн төрөөс ихээхэн гавъяа зүтгэл байгуулсан Монгол ноёдод хэргэм зэрэг цалин пүнлүү нэмж олгож байсны дээр Богд хаант Монгол улсын үед Очир дара Богд Жавзандамба хаанаас хишиг хүртээж цол хэргэм шагнаж байсан түүхтэй. Тус хошууны ноён Гомбосүрэн болвоос Манж Чин улсын үеэс Богд хаант Монгол улсын үе, Ардын засгийн эхэн үе хүртэл төр засгийн алба хүлээж, зүтгэж явсан ноёдын нэг учраас арван зэрэг нэмсэн, долоон зэрэг тэмдэглэсэн Сэцэн хан аймгийн чуулганы Да, Богд хаан улсын үед шүүх яамны дэд сайдаар ажиллаж байсны дээр Богдын зарлигаар хошой Чин ван цол хэргэм шар хүрэм, шар жолоо шагнуулж байсан засаг ноён юм.
2. Боржигин Сэцэн вангийн хошуу нутгийн зураг, хошууны газар нутгийн хилийн овоодыг тодорхойлсон цэсийг Олноо өргөгдсөний арваннэгдүгээр онд үйлдсэн байна. Энэ нь 1921 он болно.
3. Нэг газар гэдэг нь 576 метр буюу 360 алд
4. Нэг хувь гэдэг нь 57 метр
5. Нэг ямх гэдэг нь 3.2 сантиметр орчим
6. Нэг алд гэдэг нь 1.6 метр.

Эртнээс Монголчууд зүг чигийг бичгийн хэлэнд тэмдэглэж бичихдээ арван хоёр жилийн өнгөөр эр эмээр нь хувааж байрлуулан зааж иржээ. Энэ хавсралт цэсд газар зүгүүдийг жилийн өнгөөр голдуу заасан үзэгдэнэ. Хойд зүгийг хулгана, гахай: Зүүн зүгийг туулай, барс: өмнө зүгийг морь: баруун зүгийг тахиа, туулай Мөн үүнээс гадна дөрвөн зовхисыг заасан зогсолт, оролго, ээвэргүү, мөнх гэсэн нэрээр зүгүүдийг илэрхийлж байжээ. Зогсолт үхэр, барсын завсар зүүн хойд зүг: Оролго луу, могойн завсар зүүн урд зүг: Ээвэргүү хонь, бичин зүгийн завсар баруун өмнө: Мөнх нохой, гахай зүгийн завсар баруун хойд зүг юм.